



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/459

Улаанбаатар хот

Гэр хорооллын газрыг дахин
төлөвлөн барилгажуулах төслийн
байршилд зөвшилцсөнөөс бусад иргэн,
аж ахуйн нэгжид зөвшөөрөл
олгохгүй байх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх байршилд төсөл хэрэгжүүлэгч эрх бүхий хуулийн этгээд болон түүнтэй зөвшилцсөнөөс бусад иргэн, хуулийн этгээдэд барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхтэй холбоотой зөвшөөрөл олгохгүй байхыг Нийслэлийн Ерөнхий архитектор Н.Нацагдорж, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т тус тус үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

111020002256